

МОНГОЛБАНКНЫ 2011 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛӨӨС САНАЛ, ЗӨВЛӨМЖ ӨГӨВ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн хурал 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдөр болов. Тус хурлаар Монголбанкны 2011 оны санхүүгийн тайланд Хяналтын зөвлөлөөс өгөх санал, зөвлөмж, Монголбанкны захиргаа, аж ахуйн зардал, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 2011 оны гүйцэтгэл, Монголбанкинд хуримтлагдсан өр, авлагыг барагдуулах ажлын явц, үр дүн, Мөнгөний бодлого, судалгааны газраас хийсэн судалгаа, түүнийг практикт хэрэгжүүлж буй байдал зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргасан байна.

Монголбанкны Хяналтын зөвлөл нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Монголбанкны 2011 оны санхүүгийн тайланд Хяналтын зөвлөлөөс өгөх санал, зөвлөмжийг хэлэлцэв.

2011 оны санхүүгийн тайлангаар Монголбанк 3 их наяд 976 тэрбум 214 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй, өнгөрсөн жилийн мөн үетэй (2010 оны 12-р сарын 31-нд нийт хөрөнгийн дүн 3 их наяд 707 тэрбум 612 сая төгрөг байсан) харьцуулахад нийт хөрөнгийн дүн 268 тэрбум 602 сая төгрөгөөр буюу 7,2 хувиар өссөн ба тайлант хугацаанд 179 тэрбум 653 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

Хяналтын зөвлөлөөс Монголбанкны 2010 оны санхүүгийн тайланд дараах санал, зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. Монголбанкны 2011 оны санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлт (хөрөнгө, өр төлбөр, өмч, тайлант жилийн ашиг, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт зэрэг) нь хөндлөнгийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн дүнгээс нэлээд хэмжээгээр илүү тайлагнасан байгааг анхааралдаа авч цаашид санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу зөв, бодитой бэлтгэж толилуулах, уг асуудлын учир шалтгааныг тодорхой болгож, зохих арга хэмжээг авч ажиллахыг зөвлөмж болгосон байна.

2. Монголбанкны тайлант жилийн ашиг нь гадаад валютын ханшийн зөрүүнээс үүсчээ. Монголбанк төгрөгийн тогтвортой байдлыг баталгаажуулах үндсэн зорилготой, ашгийн төлөө бус байгууллага ч, хүүний болон үйл ажиллагааны зардлаа нөхөхүйц хэмжээний орлоготой буюу ашигтай ажиллах боломжийг судалж хэрэгжүүлэх шаардлагатайг зөвлөсөн байна.

3. Сүүлчийн 3 жилийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын компаниуд ижил үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд энэхүү хязгаарлалт нь Анод банкинд холбогдох зээлийн өрийг Засгийн газраас авахтай холбогдох, уг асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах шаардлагатайг Монголбанкны удирдлагад зөвлөмж болгосон байна.

2011 онд Монголбанкны системийн хэмжээгээр захиргааны болон аж ахуйн үйл ажиллагаанаас 469,5 сая төгрөгийн орлого олж, 2010 оныхоос орлого 33.0 сая төгрөг буюу 6.5 хувиар буурчээ. Орлого төлөвлөсөн хэмжээнээс (320.6 сая төгрөг) 148.9 сая төгрөг буюу 46 хувиар өссөн нь орлогыг төлөвлөх үндэслэлийг сайжруулах шаардлага байгааг тэмдэглэв.

Монголбанкны системийн хэмжээгээр 2011 онд зардлыг 14085,7 сая төгрөг байхаар төлөвлөж, гүйцэтгэл нь 10207,6 сая төгрөг болж, төлөвлөсөн хэмжээний 72 хувьтай тэнцэж байна. Зардал нийт дүнгээрээ 3,785.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Захиргааны зардлын тал хувийг цалин хөлс, нийгмийн халамжийн зардал эзэлж байна. Нийт зардал өмнөх оныхоос 35,3 хувиар өсчээ. 2011 оны хөрөнгө оруулалт гүйцэтгэлээр 2149,8 сая төгрөг болж 2009 оныхоос 31.7 хувиар их, 2010 оныхоос 5,3 хувиар бага гарчээ. 2011 онд төлөвлөсөн хэмжээнээс 31,9 хувиар дээгүүр байна.

Хяналтын зөвлөлийн хурлаас Монголбанкны орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган дүнг Монголбанкны Зөвлөлийн хурлаар хэлэлцдэг журам тогтоохын хамт төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, Монголбанкны өөрийн орлогыг нэр төрлөөр төлөвлөн гүйцэтгэлийг гаргадаг болох, Хадгаламж болон Голомт банкинд түрээслүүлж байгаа байрны талбайн түрээсийн төлбөрийг зах зээлийн үнэ, ханшид нийцүүлэн нэмэгдүүлэх арга хэмжээ авах, Монголбанкны захиргаа, аж ахуйн төсвийн болон хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн асуудлыг 2009, 2010 онд Хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэн хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлэх асуудлаар Монголбанкны удирдлагад зөвлөмж хүргүүлсэн байна.

Монголбанк 2011 онд нийт 2,445,029,629.00 төгрөг, 439,122.00 ам доллар болон 3,536.50 фунт стерлингийн өр төлбөрийг барагдуулж, 8 иргэнд холбогдох авлагыг бүрэн шийдвэрлэж дуусгасан байна.

Өр төлбөрийг барагдуулах ажилд ахиц дэвшил байгаа боловч энэ ажил удаашралтай байгаад дүгнэлт хийж, цаашид эрчимжүүлэх нь зүйтэй гэж үзэв. Төлбөрөө барагдуулж эхлээгүй буюу барагдуулахаас татгалзаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагатай тодорхой ажил зохиож ажиллах, авлага барагдуулах ажиллагаандаа эрх зүйн арга хэрэгслийг зөв хэрэглэх тухай Хяналтын зөвлөлийн шийдвэрт тусгагдсан байна.

Монголбанкны удирдлага судалгааны материаллаг баазыг бэхжүүлэн программ хангамжийг сайжруулан мөнгө, валют, инфляцийг тооцох магадлалыг нарийвчлах аргачлал, загварыг шинээр боловсронгуй болгон хэрэглэх, гадаадын байгууллагуудтай хамтарсан судалгааг зохион байгуулах зэрэг ахицтай олон талтай шинэлэг үйл ажиллагаа явуулж ирсэн ч, бодлогын нэгдсэн судалгаа явуулах, үр дүнг нь эдийн засгийн үзүүлэлтээр тооцон гаргах, энэ чиглэлээр алба, ажилтнуудыг мэргэшүүлэх, мэдээллийг түгээн тараах, олны хүртээл болгох зэрэг асуудалд анхаарч ажиллах шаардлагатайг Хяналтын зөвлөлөөс тэмдэглэв.

Хяналтын зөвлөлөөс Монголбанкны удирдлагад дараах зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

- Судалгааны ажлыг газар, хэлтэс бүр өөр өөрийн шугамаар хийхээр хариуцуулсан одоогийн бүтцийг судалгааны үйл ажиллагааг нэгдсэн болон газар хэлтэс бүрт хариуцуулсан хосолмол хэлбэрт шилжүүлж ажиллах боломжийг судлан үзэх;

- Судалгааны ажлын сэдвийг ангилах, нэгдсэн хэлбэрээр хийх бодлогын суурь судалгааны сэдэв, үр дүнг Захирлуудын зөвлөлөөр хэлэлцэн дүгнэж байх;

- Ирээдүйд чиглэсэн, амьдрал ба эмпирикт суурилсан судалгааны сэдэв, тоог нэмэгдүүлэн үр дүнг бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглахад илүү анхаарах;

- Бүх төрлийн судалгааны явц, үр дүнг сонирхогч болон ирээдүйд үр шимийг хүртэгч талуудын оролцоотойгоор хэлэлцүүлэх, тэдний санал хүсэлт, байр суурийг тусгах, олон нийтэд өргөн сурталчилах, судалгааны ажилд зарцуулж байгаа хөрөнгө, санхүүжилтийн үр өгөөжийн байдлыг гаргаж Монголбанкны Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүнг Хяналтын зөвлөлд танилцуулах;

- Судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн үзүүлэлтээр дүгнэж ажиллах журам гаргах, судалгааны ажил явуулахад баримтлах бодлогын баримт бичигтэй болох зэрэг болно.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ